

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр, Пүрэв гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-8
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	9-33
1. “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	9-15
2. Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох тухай /Монгол Улсын Ерөнхийлөгч 2025.12.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/	16-33

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
12 дугаар сарын 18-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 9 цаг 52 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Э.Болормаа, Б.Жаргалан, Г.Очирбат, Б.Тулга, Г.Хосбаяр, Д.Цогтбаатар;

Чөлөөтэй: Ч.Анар, Л.Оюун-Эрдэнэ, Ө.Шижир;

Эмнэлгийн чөлөөтэй: Г.Тэмүүлэн, Л.Гантөмөр;

Тасалсан: С.Лүндэг.

Нэг. “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх М.Отгон, референт Б.Гандиймаа нар байлцав.

Тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир, Р.Эрдэнэбүрэн, П.Сайнзориг нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Д.Энхтүвшин: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 4

Бүгд: 16

75.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох тухай /Монгол Улсын Ерөнхийлөгч 2025.12.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Гадаад бодлогын зөвлөх Э.Одбаяр, Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал Б.Болд, мөн яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал Ж.Соёлмаа, Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлагын газрын дэд захирал Б.Нямдаваг, элчин сайдад нэр дэвшигч Г.Тэнгэр, Д.Мөнхтөр, Г.Байгалмаа, А.Баттөр, Г.Хулан, Ж.Оюунбаатар, Д.Бямбадорж, Д.Булган, Б.Мөнхжин, Г.Батжаргал, Д.Тэгшжаргал, Д.Даваа, Г.Уянга, О.Лхагвасүрэн, Н.Энхтайван, Ц.Мөнх-Оргил, Б.Болормаа, А.Ананд, Л.Өлзийт, В.Оюу, Д.Баттөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх М.Отгон, референт Б.Гандиймаа нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн зарим Элчин сайд нарыг эгүүлэх татах асуудлаар зөвшилцөх тухай асуудлыг хамтад нь хэлэлцэх горимын санал гаргав.

Д.Энхтүвшин: Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	5
Бүгд:	16

68.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Гормын санал дэмжигдсэн тул дээрх асуудлыг хамтатган хэлэлцэхээр тогтов.

Монгол Улсаас гадаад улсад суух Элчин сайд нарыг томилох, эгүүлэн татах асуудлаар зөвшилцөх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Гадаад бодлогын зөвлөх Э.Одбаяр танилцуулав.

Нэр дэвшигчид болон танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаяр, Л.Эхнасан, С.Эрдэнэболд, П.Наранбаяр, Ц.Мөнхбат, Р.Эрдэнэбүрэн, Н.Батсүмбэрэл нарын тавьсан асуултад Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, нэр дэвшигч Г.Тэнгэр, Ц.Мөнх-Оргил, Д.Даваа, Д.Баттөр, Г.Батжаргал нар хариулж, тайлбар хийв.

Д.Энхтүвшин: 1.Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамдинсүрэнгийн Даваасүрэн;

2.Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Мижиддоржийн Цэнгэг;

3.Монгол Улсаас Бүгд Найрамдах Беларусь Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Батсүхийн Баярсайхан;

4.Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Лхагвасүрэнгийн Саянаа;

5.Монгол Улсаас Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жигжээгийн Сэрээжав;

6.Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бирваагийн Мандахбилэг;

7.Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Энхтүвшингийн Булган;

8.Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Цэрэндоржийн Нарантунгалаг;

9.Монгол Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Баттөмөрийн Энхсүх;

10.Монгол Улсаас Бүгд Найрамдах Казакстан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Доржхүүгийн Баярхүү;

11.Монгол Улсаас Бүгд Найрамдах Киргиз Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Содномын Ганхуяг;

12.Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Өлзийсайханы Энхтүвшин;

13.Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Сосорбарамын Энхбаяр;

14.Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Гомбосүрэнгийн Мөнхбаяр;

15.Монгол Улсаас Унгар Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Сайннямбуугийн Баатаржав;

16.Монгол Улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Уламбаярын Нямхүү;

17.Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамдины Гансүх;

18.Монгол Улсаас Арабын Нэгдсэн Эмират Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шижээхүүгийн Одонбаатар;

19.Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Дамбажавын Ганболд;

20.Монгол Улсаас Тайландын Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Амарсанаагийн Төмөр;

21.Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жамсрангийн Бямбасүрэн нарыг эгүүлэн татах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6

Бүгд: 17

64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Энхтүвшин: 1.Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гончигзэвэгийн Тэнгэрийг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Доржраагийн Мөнхтөрийг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Монгол Улсаас Бүгд Найрамдах Беларусь Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Байгальмааг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Авирмэдийн Баттөрийг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Монгол Улсаас Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Ганбаатарын Хуланг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Жагдагийн Оюунбаатарыг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Доньжчимбуугийн Бямбадоржийг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дансрангийн Булганыг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Монгол Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батсүмбэрийн Мөнхжинг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Монгол Улсаас Бүгд Найрамдах Казакстан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Батжаргалыг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Монгол Улсаас Бүгд Найрамдах Киргиз Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дэмчигийн Тэгшжаргалыг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дуламсүрэнгийн Давааг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Ганболдын Уянгыг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Очирын Лхагвасүрэнг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Монгол Улсаас Унгар улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Нямцэрэнгийн Энхтайванг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Монгол Улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэндийн Мөнх-Оргилыг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батсайханы Болормааг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Монгол улсаас Арабын Нэгдсэн Эмират Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Амгалангийн Анандыг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лувсанжавын Өлзийтийг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Монгол Улсаас Тайландын Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Вашагийн Оюуг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Даваахүүгийн Баттөрийг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 36 минут үргэлжилж, ирвэл зохих 29 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 58.6 хувийн ирцтэйгээр 11 цаг 28 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
9 цаг 52 минут.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Д.Энхтүвшин: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны ирц бүрдсэн тул Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Гишүүдийн ирцийг танилцуулъя. 29 гишүүнээс, 15 гишүүн ирсэн байна.

Бат-Амгалан, Ганбат, Наранбаяр, Энхбаяр, Энхтүвшин, Батсүмбэрэл, Жангабыл, Номтойбаяр, Энхбаяр, Жадамбаагийн Энхбаяр, Эрдэнэболд, Бум-Очир, Мөнхбат, Тэмүүжин, Энхнасан, Эрдэнэбүрэн нарын гишүүд ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 2 асуудал байгаа.

1 дүгээрт нь “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг

2 дугаарт нь Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2025 оны 12 сарын 15-ны өдөр зөвшилцөхөөр өргөн мэдүүлсэн, Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай гэсэн ийм 2 асуудал байна.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу. Батсүмбэрэл гишүүн. Батсүмбэрэл гишүүнд микрофоныг нээе.

Н.Батсүмбэрэл: Хэлэлцэх асуудлын тэр 2 дугаар асуудал дээр өмнө нь эргүүлэн татахаар 2 сайдын нэр, материал байгаа юм байна. Тэрийг хамтатган хэлэлцэх ийм саналтай байна.

Д.Энхтүвшин: Батсүмбэрэл гишүүний тавьж байгаа асуудал зөв үү. Тэгээд энэ дээр өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой 2 асуудлыг нэгтгээд, яг 2 дахь асуудал хэлэлцэх үед нь нэгтгэж хэлэлцэхээр горимын санал гаргаад, тэгээд тэр үед нь санал хураалт яваад шийдээд явчихъя. Өөр хэлэлцэх асуудал саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

1 дэх асуудал.

“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эхэлье.

Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа танилцуулна. Ариунзаяа гишүүнд микрофон өгье.

А.Ариунзаяа: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ. Өглөөний мэнд хүргэе та бүхэндээ.

Улсын Их Хурал Монгол Улс болон Евроазийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг бид хамтдаа 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр хэлэлцэн баталсантай холбогдуулан “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, батлуулах ийм зарчмын зөрүүтэй санал гаргаж, дэмжигдэж та бүхэнд өнөөдөр танилцуулж байна.

Дээрх хуулийн төслийг хэлэлцэх үеэр миний бие санал гаргаж, тамхины онцгой албан татварын асуудал, тамхины хэрэглээнд хяналт тавих хэлэлцээрийн биелэлтэд 3 жил тутамд бас хяналт шинжилгээ, үнэлгээг хийж, үнэлгээний тайланг Улсын Их Хуралд танилцуулж байх, “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж батлуулах санал гаргаж та бүхэнд танилцуулж байгаа.

Худалдааны тус түр хэлэлцээрээр 367 барааны гаалийн татварын хувь хэмжээг хөнгөлөх, чөлөөлөхөөр заасан бөгөөд эдгээр барааны жагсаалтын 92, 93, 94 дүгээрт тамхи агуулсан янжуур болон бусад тамхины гаалийн татварыг тэглэхээр тусгасан байгаа юм.

Тэгэхээр Засгийн газар тамхи агуулсан янжуур болон бусад тамхины гаалийн тарифыг тэглэснээр иргэдийн тамхины хэрэглээ нэмэгдэх, бид яг хэрэглээг нь хязгаарлах тэр үнийн татварын бодлогоор бас тамхины хэрэглээг хязгаарлах бодлого маань эрсдэлд орж байгаа учраас гаалийн тарифыг онцгой албаны татвараар орлуулах, онцгой албан татварыг нэмэгдүүлэх, тамхинд мөн квот тогтоох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж, тамхины хэрэглээний өсөлтийг хязгаарлах боломжтой гэж үзэж байна.

Иймээс Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дэх дэд заалтаар тамхи агуулсан янжуур болон бусад тамхины гаалийн тарифыг тэглэсэнтэй холбогдуулан нийтийн эрүүл мэнд, эдийн засаг, улсын төсөв, татварт нөлөөлөх үр дагаврын дүн шинжилгээ хийж тамхины гаалийн татварыг нөхөх, тамхины онцгой албан татварыг нэмэгдүүлэх тооцооллыг хийж, холбогдох хууль тогтоомжийн төслийг 2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт бас даалгаж байгаа. Яагаад 4 сарын 15 бэ гэхээр хуулийн төслийг боловсруулах хугацаа олон нийтэд танилцуулах, саналыг нь авах, Засгийн газрын гишүүд хоорондын саналыг нь авах, 60 хоног байршуулах гэх хугацаануудыг оруулаад 4 сарын 15-ны дотор Засгийн газар өөрийнхөө хэмжээнд хийх ёстой бүхий л ажлуудаа хийж хэрэгжүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүргийг хүлээх ёстой гэж үзэж байгаа.

Мэдээж түүнээс өмнө өргөн барьчих юм бол сайн. Бид хаврын чуулган 3 сарын 15-нд нээгдэхэд бид шууд энэ хуулийн төслийг хэлэлцэх боломжийг бүрдүүлж ирвэл маш сайн байна.

Тогтоолын төслийн 2 дахь дэд заалтад Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн шатад байгаа Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдаад, хоригийн хугацаа, албажих хугацааг оруулаад, хэрэгжиж эхлэх хүртэлх хугацаанд тамхи, тамхин бүтээгдэхүүн, электрон тамхины импортын хэмжээг бас 2024 оны сар болгоны хэмжээнээс хэтрүүлэхгүй байх хязгаар, квотыг

Засгийн газар бас тавих ийм үүрэг даалгаврыг бас өгч байна. Мэдээж бид энэхүү хугацаанд ямар нэгэн байдлаар тогтоол аль аль хууль батлагдахгүй бол маш бага татвартай тамхийг нөөцлөн авчих вий гэдэг ийм болгоомжлол байгаа учраас ийм квот тогтоохыг Засгийн газарт даалгаж байгаа юм.

Түүнчлэн Улсын Их Хурлын тогтоолын төслийн 3 дахь дэд заалтад худалдааны түр хэлэлцээрт нэгдэн орсон талууд хэлэлцээрийг 3 жилийн хугацаатай байгуулах бөгөөд талууд өөрөөр тохиролцоогүй бол хугацааг сунгасанд тооцох тул Засгийн газар уг хэлэлцээрийн биелэлтэд 3 жил тутамд хяналт шинжилгээ, үнэлгээг хийж, үнэлгээний тайланг Улсын Их Хуралд танилцуулахаар тогтоолын төсөлд багтаасан байгаа. Энэ ямар учиртай юм бэ гэхээр хэдийгээр бид Евроазийн хэлэлцээрийг түр хэлэлцээр гэж байгаа боловч 3 жилийн хугацаатай. 3 жилийн дараагаар талууд ямар нэгэн санал гаргаагүй бол шууд автоматаар сунгагдаад явах ийм заалттай. Ийм учраас бидний хувьд Монгол Улсад ашигтай байна уу. юу тулгамдаж байна вэ. Яаж асуудлуудыг шийдвэрлэх вэ гэдгийг 3 жил тутамдаа дүгнэж байх шаардлагатай гэж үзэж байгаа. Тогтоолын хэрэгжилтийг бол 3 Байнгын хороонд даалгасан. Евроазийн хэлэлцээрийг байгуулахад бас 3 Байнгын хороогоор орж, зөвшөөрөл нь олгогдсон учраас энэ 3 Байнгын хороо ч гэсэн хэлэлцээр сайн явж байна уу, үгүй юу, засвар хийх үү, ямар ажлууд тулгамдаж байна вэ гэдгийг бас хэлэлцэх нь зүйтэй гэж үзэж, Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо зэрэгт бас тус тус даалгасан байгаа.

Ингээд “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж, шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсэж байна. Баярлалаа.

Д.Энхтүвшин: Танилцуулга хийсэн Ариунзаяа гишүүнд баярлалаа. Тогтоолын төслийг та бүхэнд хүргүүлчихсэн байгаа. Тэгээд Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу. Эрдэнэбүрэн гишүүнээр тасалъя. Бум-Очир гишүүнд микрофон өгье.

Д.Бум-Очир: Баярлалаа. Тогтоолын төслийг дэмжиж байгаа. Тэгээд 1 зүйл тодруулах гэсэн юм. Энэ бараг нэр томьёотой холбоотой болов уу. Тамхи агуулсан янжуур гэж яг ийм тамхины тусгай зүйл байгаа юу.

Зүгээр ингээд шууд үгээр нь бодоод үзэхэд тамхи, янжуур 2 гээд 2 өөр зүйлийг хэлж байгаа юм шиг. Тэгэхээр тамхи агуулсан янжуур гэхээр тамхи агуулаагүй янжуур гэж бас байдаг юм болов уу гээд бас бараг танин мэдэхүйн чанартай ч юм шиг. Эсвэл томьёолол нь буруу байх вий дээ гэж бас бодсон үүднээс энийг тодруулахыг хүслээ. 1 дээр байж байгаа. 1.1 дээр. Энийгээ яг 1.1 дэх зүйл дээр тамхи агуулсан янжуур болон бусад тамхины гаалийн тариф гэж томьёолсон байгаа. Энийг зүгээр тамхи, тамхин бүтээгдэхүүн, электрон тамхи гэж доор 1.2 дээр томьёолсон байгаа шиг томьёолоод явах нь илүү зөв бөгөөд өргөн хүрээтэй байх байсан болов уу гэж тодруулах гэсэн юм.

Д.Энхтүвшин: Ариунзаяа гишүүн хариулъя.

А.Ариунзаяа: Таны асууж байгаа асуулт бол зөв. Гэхдээ тухайн энэ тогтоолд оруулсан томьёолол бол Евроазийн хэлэлцээр дээр томьёологдсон байгаа тэр томьёоллоор нь бөгөөд тухайн Гаалийн өөрийнх нь барааны бичиглэл дээр нь суурилж яг ижилсүүлж ямар нэгэн зөрчил үүсгэхгүйн тулд, агуулгын зөрчил

үүсгэхгүйн тулд яг энэ хэвээр нь оруулсан байгаа юм. Тэгэхээр Монгол Улсад одоогоор мөрдөгдөж байгаа гаалийн болон бусад энэ Евроазийн хэлэлцээрээр ч гэсэн томьёоллын зөрөөгүй оруулж ирсэн гэж ойлгоно.

Д.Энхтүвшин: Эрдэнэбүрэн гишүүн.

Р.Эрдэнэбүрэн: Өдрийн мэнд хүргэе. 2, 3 асуулт байгаа юм. Энэ хэлэлцээрийн дараа Ариунзаяа гишүүн л их зүтгүүлээд байгаа юм. Хэлэлцээрийн ардаас ингээд ийм тогтоол оруулж ирээд яваад байгаа. Энэ нөгөө тооцоо байдаг юм уу. Хийж хийсэн үү. Ямар хэмжээний юутай, татвар нь өөрчлөгдөх юм. Энэ үнэ нь юу болох юм гээд тооцоо байдаг уу. 1 дүгээрт.

2 дугаарт бид нар бас Тамхины хууль гээд явж байгаа тэр энэ тэртэйгээ хэр нийлж байгаа вэ энэ тогтоол чинь.

3-д нь бол ер нь бид нар энэ архи, тамхины хэрэглээг одоо ингээд яах вэ, нэг хэсэг хууль гаргаад, ялангуяа тамхийг бол хаана татах вэ, ямар байршилд зарах вэ энэ тэр гээд тэр зохицуулалтуудыг нь нэлээн сайн хийж өгөөд, үр дүнтэй болсон. Тэгээд одоо сүүлийн үед тамхи, архины хэрэглээтэй их ноцолддог боллоо. Би бол үүний жоохон эсрэг байгаа. Үнэтэй болгох замаар бага татуулна энэ тэр гэдэг бол худлаа зүйл шүү дээ. Тэгээд архи тамхины хэрэглээтэй бид нар чинь бас нэг үеийг бодвол архийг чинь жилд 2 градусаар юуг нь буулгаад, зөөлрүүлээд ингээд явж байгаа. Гэтэл ингээд үнийг нь нэмэх замаар ч юм уу, аль болох татуулахгүй, уулгахгүй байна гэдэг ийм зарчим руу хориглож явах гэж оролдох юм бол үүний оронд чинь нөгөө хар тамхи гэдэг юм чинь орж ирэх гээд байгаа юм шиг санагдаад байгаа шүү.

Дахиад өөр алтернатив янз бүрийн нөгөө электрон тамхи эд нар чинь бүгдээрээ давхиад орж ирэх гээд байгаа юм. Тийм учраас энэ чиглэл рүү их довтолдог бол бас багасгамаар санагдаад байгаа юм. Ариунзаяа гишүүн бол өөрөө өөр зүйл яриад байх шиг байна. Тэгээд энэ чиглэлээр энийг ер нь юу гэж бодож байгаа юм бэ гээд асуучихъя.

Д.Энхтүвшин: Ариунзаяа гишүүн хариулъя.

А.Ариунзаяа: Эрдэнэбүрэн гишүүний бас хөндөж байгаа асуудлууд бол зөв. Бид нар зүгээр л үнэ юм уу эсвэл татвараар дамжуулаад, тамхины хэрэглээг дангаар нь бууруулах гээд байгаа юм шиг асуудал дан тийм асуудал бол байхгүй. Ер нь гэхдээ энэ бол татвараар тамхины үнийг зохицуулах арга хэрэгслийн зөвхөн 1 хэлбэр нь бол мөнөөс мөн. Энийг бол үгүйсгэх боломжгүй. ДЭМБ ч тэр, бусад улс орнууд ч тэр татварын бодлогоороо тамхийг ер нь үнэтэй болгож байж, тэгээд үүгээрээ дамжуулаад 1 дүгээрт юу гэдэг юм бага насны хүүхдүүд, өсвөр насны хүүхдүүд амархан энэ тамхийг худалдаж авдаг байдлыг зогсоох, нөгөө талаасаа нийгмийн эрүүл мэндийг бас хамгаалах, тамхины татваруудаас нь бүрдэж байгаа тусгайлсан санг байгуулаад нийтийн эрүүл мэндэд мэдээ мэдээллээр хангахаас гадна нийтийн эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагаануудыг явуулах зэрэг ийм одоо бодлогуудыг бол авч хэрэгжүүлдэг. Евроазийн хэлэлцээрийг бид нар ярилцаж байхад Номинчимэг гишүүн нэн ялангуяа яг энэ Тамхины хуулийг санаачилж явж байгаа гишүүний хувьд гаалийн онцгой албан татварыг тамхи, тамхин бүтээгдэхүүн дээр тэглэж байгааг бид нар ердөөсөө үл анзаарч орхигдуулсан байна. Энэ бол буруу гэдгийг хэлсэн. Тамхины хууль бол зэрэгцээд явж байгаа. Яг одоо Улсын Их Хурал дээр ажлын хэсэг ажиллаж байгаа. Энэ ажлын хэсгийн ажил маань энэ ондоо

багтаад энэ намрын чуулгандаа багтаад хуулиа батлаад явбал маш сайн. Гэтэл нөхцөл байдал тийм биш байна. Бид нар Евроазийн хэлэлцээрийг баталчихсан байна. Тамхины хууль хэзээ батлагдах вэ гэдэг нь тодорхойгүй байна. Ийм учраас энэ хоорондын хугацаанд бид нар ямар нэгэн байдлаар гайп үүсгэж болохгүй юм. Татваргүй тамхийг оруулж болохгүй энэ чинь нөөцлөх маш их эрсдэлтэй. Ийм учраас энэ дагасан тогтоолыг гаргах юм гэдэг ийм хамтын ойлголцол дээр суурилад энэхүү тогтоолыг бас боловсруулж гаргаж ирж байгаа гэж ойлгох хэрэгтэй. Дэмжиж өгөхийг хүсье.

Д.Энхтүвшин: Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Яах вэ, энэ тогтоолын төслийг зарчмын хувьд бол дэмжээд байгаа юм. Агуулгын хувьд. Тэгэхдээ энэ дээр бас хэлбэр цаашдаа бид нарын нөгөө Улсын Их Хурлаас чиглэл өгч байгаа юмнууд дээр анхаарахгүй бол ийм байна. Одоо жишээ нь захиргааны хэм хэмжээний актыг Засгийн газар батлахдаа буюу хуулиар эрх олгосон тохиолдол гаргана. Аливаа бизнесийн үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох гэж байгаа. Тэгээд энэ 2 дугаар заалтаар чинь ингээд тогтоолоор хязгаарлалт өгөх гээд байна шүү дээ. Тэгээд бид хэд энийг чинь баахан хэрүүлтэй уруултай нөгөө Хууль тогтоомжийн хууль ярьж байхад энийг л яриад байсан шүү дээ. Тэгээд Байнгын хороо дээр ингээд зарчмаа алдагдуулаад, агуулга нь зөв боловч хэлбэр нь буруу тэгээд ийм байдлаар яваад байж болох уу, үгүй юу. Би энэ Байнгын хороо биш. Тэгэхдээ чуулган дээр орж ирээд хэрүүл хийж байхаар наана нь засаасай гэж бодоод орж ирээд хэлж байгаа юм.

Тэгэхээр 2 дугаар зүйлийн чинь хувьд энэ Хууль тогтоомжийн тухай хууль болон бусад тэр юмтай чинь нийцэж байгаа юм уу гэдэг зүйл 1 дүгээрт байна. Би агуулгыг нь дэмжээд байгаа. Тэгэхдээ ингэж хуулиар бус тогтоолоор хязгаарлалт тогтоогоод энийг нь Засгийн газраар хэрэгжүүлэх эрх зүйн үндэстэй юу. Энийгээ 1 дүгээрт хэлээч.

2 дугаарт уг нь олон улсын иргэний нисэхийн Чикагогийн конвенцод нэгдэж орохдоо Засгийн газрын өргөн мэдүүлснээр нэгдээд, дараа дараагийн техникийн үзүүлэлттэй холбоотой нэгдэж шинээр батлагдаж байгаа тэр хэлэлцээрүүдийг Засгийн газар хүлээгээд авчих тийм эрх олгосон заалт өгч байсан юм. Тэгэхээр би юу хэлэх гэж байна гэхээр энэ тогтоолын 3 дахь заалт дээр байгаа хэлэлцээрийн биелэлт 3 жил тутам хяналт шинжилгээ хийхийг уг нь тэр хууль дээр хийх ёстой байхгүй юу. Хууль дээр л хяналт шинжилгээ хийх гээд байгаа юм. Тэгээд энэ тогтоол гээд хэлэлцээр дээрээ байна. Тэгээд 3 жил тутам гэдэг чинь өөрөө энэ хэлэлцээр чинь автоматаар сунгагдсаны дараа дахиад хийх гээд байгаа байхгүй юу. 2 жил тутам байхгүй. Тэгээд энэ заалттай холбоотойгоор магадгүй энэ нөгөө Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль дээр ийм төрлийн асуудлыг хэлэлцэх ерөнхий дэг байгаа. Тэгэхээр энийг тодруулж цаашдаа өгөх ёстой. Байнгын хорооноос чиглэл өгөөд, ялангуяа хугацаатай өгсөн энэ хууль тогтоомжийн төслүүдийг хугацаанаас нь өмнө материалыг нь авахаас эхлээд, яаж хэлэлцэх вэ гэдэг зүйлийг оруулж өгөх ёстой. Хаврын чуулганаар уу, намрын чуулганаар уу гэдэг юмыг нь тодорхой болгож өгөхгүй бол энэ чинь их сонин болох гээд байна. Нөгөө хэлэлцээр маань 3 жилийн хугацаатай, 3 жилийн дотор автоматаар сунгагдана. Дараа нь талууд гарлаа гэж мэдэгдэхгүй бол. Тэгэхээр энэ чинь 3 жил тутам хяналт шинжилгээ хийгээд, автоматаар сунгасны дараа хяналт шинжилгээ хийнэ гээд байгаа юм.

2 дугаарт хяналт шинжилгээ хийнэ гэдэг нэр томьёо нь буруу. Хяналт шинжилгээ гэдэг чинь өдөр тутмын юм байхгүй юу. Энэ хууль тодорхой хэлэлцээр дээр бол хэрэгжилтийн үр дагавар буюу цаашдаа эерэг, сөрөг юу авчрав гэдэг зүйл дээр дүгнэлт өгдөг болохоос биш өдөр тутам хяналт шинжилгээ хийх ямар ч боломж байхгүй. Тэгэхээр энийг нэр томьёоны хувьд засаач ээ. Энэ тогтоолын буюу хэлэлцээрийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, 2 жил тутамд танилцуулах ёстой л гэж би зүгээр хувьдаа үзэх гээд байгаа юм. 3 жил тутам гэвэл нөгөө хэлэлцээр чинь автоматаар сунгагдчихна шүү. Тэгээд ингээд баахан хэрүүлтэй уруултай ингэх байсан, тэгэх байсан гээд юмнууд чинь явна. Тэгэхээр энэ 2 техникийн саналыг хэлчихье. Тэгээд энэ 2 дахь заалт .../минут дуусав/

Д.Энхтүвшин: Сайнзориг гишүүн яг тодорхой санал байвал та томьёолоод хэлээч. 2, 3 дээр нь.

П.Сайнзориг: Нөгөө хуулиар хязгаарлах ёстой юмыг тогтоолоор хязгаарлаж өгч байгаа нь зөв үү. Энэ дээрээ тайлбараа өгчих. Би агуулгыг нь дэмжээд байгаа. Тэгэхдээ энэ агуулга зөв байна гээд хэрэгжүүлэх хэлбэрийн хувьд буруу байж болохгүй шүү дээ. Ингээд хэдүүлээ 1 юм яриад л нөгөө талдаа.

2 дугаарт энэ 3 дугаар заалт чинь 3 жил тутамд гэхихжээ. Тэгэхээр энэ Евроазийн хэлэлцээрт бид нэгдэж орохдоо 3 жилийн хугацаатай орсон. Үүний дараа автоматаар сунгагдаад явна. Гарлаа гэдгээ мэдэгдэхгүй бол. Тэгэхээр 3 жил тутамд дүгнэлтээ өгнө гэхээр энэ чинь сунгагдсаны дараа энэ хяналт шинжилгээ чинь буюу хэрэгжилтийн үр дагаврыг чинь ярих гээд байна. Тэгэхээр 2 жил тутамд гээд хийчхэж болохгүй юм уу л гэдэг зүгээр санал байгаа байхгүй юу. Би агуулгыг нь дэмжээд байгаа юм. 3 жил тутам гэдгээ 2 жил тутам.

Д.Энхтүвшин: Ариунзаяа гишүүн хариулъя.

А.Ариунзаяа: Хэлэлцээр дээр хэрэгжих хугацаа болон хэлэлцээрийн тусгайлсан зүйл, заалтууд байгаа. Энэ дээр болохоор 28 дугаар зүйл дээр хэлэлцээрийг хүчинтэй хугацаа, хэлэлцээрээс гарах болон цуцлах нөхцөлүүдийг бас тусгайлаад заагаад өгчихсөн байгаа юм. Тэгэхээр яг эхний 3 жилийн хугацаандаа 3 жил дотроо бол ямар нэгэн өөрчлөлт хийгдэх боломжгүй. 4 дэх жилээсээ эхний хэлэлцээр хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн эхний 3 жилийн хугацаа дууссанаас хойш 1 жилийн дотор талуудын хоорондын худалдааны ихэнх хэсэгт хамаарах татварын болон худалдааны бусад хязгаарлалтыг арилгах, худалдааг хөнгөвчлөх зорилгоор энэхүү хэлэлцээрийг хянан үзнэ гээд хэлэлцээр дээр заагаад өгчихсөн заалт байгаа байхгүй юу. Тэгэхээр хэрэвзээ талууд 4 дэх жилдээ энэхүү хэлэлцээрээ үнэлээд цуцлах нь зүйтэй гэж аль нэг тал нь зэх юм бол мэдэгдлийг хүлээн авагч тал хүлээн авснаас хойш 13 дахь сар дээр энэхүү хэлэлцээрийг хүчингүйд тооцно гээд тухайлаад хугацааг заагаад өгчихсөн байгаа юм. Тэгээд ийм учраас 3 жил тутамдаа үнэлгээ хийе гэдэг ийм саналыг бол оруулж байгаа. Тэгээд 3 жил тутамдаа үнэлгээгээ хийгээд, 4 дэх жил дээрээ манай Улсын Их Хурлаас хэрэвзээ цуцална гэдэг шийдвэрийг гаргах юм бол талууддаа хүргэх ийм боломж бүрдэх хэлэлцээр батлагдсан байгаа учраас энэхүү заалтаар 3 жил тутамд гэж оруулсан байгаа юм.

Д.Энхтүвшин: Засгийн газрын байр суурийг сонсьё. Эдийн засгийн сайд Энхбаяр сайдад микрофон өгье.

Ж.Энхбаяр: Евроазийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнуудтай хийх гэрээний соёрхон батлах үйл явцтай зэрэгцээд, Тамхины хяналтын тухай хууль зэрэгцэж гишүүд өргөн барьсан. Үүнтэй холбоотойгоор тамхины татвартай холбоотой зохицуулалт зөрчил үүсэж байгаа. Энийг засах үүднээс Засгийн газарт гэрээ соёрхон баталсантай холбогдуулан Улсын Их Хурлын тогтоолоор ингээд үүрэг өгөхөд Засгийн газар энийг эрх хэмжээнийхээ хүрээнд зохион байгуулаад, хуулийн өөрчлөлтийг хаврын чуулганд оруулаад хэлэлцүүлэх бололцоотой буюу худалдаанд, бизнесийн өрсөлдөөнд тэгш зарчмыг хангах, аль нэгэн орон, аж ахуйн нэгжид давуу байдал олгохгүйгээр зохицуулах бүрэн бололцоотой. Тэр хэлэлцээний биелэлтээ 3 жил тутам хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээд Их Хуралд танилцуулна гэдэг нь өөрөө 2 талаасаа ажлын хэсэг, хороод ажиллана. Энэ бол байнгын үнэлгээ, тогтмол үнэлгээ хийгдэж явна. Жил болгон хийгдээд л явна. Энэ нэгэнт хийж байгаа ажил. Энэ дээр Их Хуралд танилцуулах, энэ дотроо Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд гэрээний хэрэгжилтийг танилцуул гэдэг үүрэг өгвөл бид жил болгон үр дүнг танилцуулаад л яваад байх бололцоотой.

Д.Энхтүвшин: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авлаа. Тэгээд сая Эрдэнэбүрэн болон Сайнзориг гишүүний саналуудыг бас яг энэ тогтоолын төсөлд хэлэлцүүлэг цаашид үргэлжлэхдээ анхаарах хэрэгтэй санагдлаа. Тэгээд Эрдэнэболд гишүүн санал байна уу. Та горимын санал гаргах юм байна тийм үү. Эрдэнэболд гишүүнд микрофон өгье.

С.Эрдэнэболд: Горимын санал гаргая. Хурал даргалагчид хандаад, анхны хэлэлцүүлгээр нь дэмжье гэсэн горимын санал гаргаж байна.

Д.Энхтүвшин: Эрдэнэболд гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалтад бэлтгэе.

“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын саналаар санал хураалт явуулъя. Гишүүд саналаа өгнө үү. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, хуралд оролцсон гишүүдийн 75 хувь нь дэмжсэн. Татгалзсан 4 гишүүн. 75 хувийн саналаар дэмжигдлээ.

“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболд танилцуулна.

10.14 цаг.

Дараагийн асуудалдаа оръё. Ажлын хэсгийг оруулъя.

Түрүүн Батсүмбэрэл гишүүний гаргасан саналтай холбоотойгоор горимын санал гаргая.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд зөвшилцөхөөр 2025 оны 6 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн Элчин сайд нарыг эгүүлэн татах асуудлаар зөвшилцөх тухай, 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн Элчин сайд нарыг эгүүлэн татах томилох асуудлаар зөвшилцөх тухай асуудлыг хамтад нь хэлэлцэхээр горимын санал гаргаж байна.

Горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлдье. Санал хураалт. Хамтатган хэлэлцэх горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтын дүнг танилцуулъя. 68,8 хувиар санал дэмжигдлээ. Хамтатган хэлэлцэх горимын санал дэмжигдсэн тул Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналуудыг хамтад нь хэлэлцээд явъя.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор өөр горимын санал байхгүй. Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Гадаад бодлогын зөвлөх Эрдэнэцогтын Одбаяр, Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг, Консулын газрын захирал Бат-Очирын Болд, Гэрээ, эрх зүйн газрын захирал Жамбалдоржийн Соёлмаа, Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлагын газрын дэд захирал Баярсайханы Нямдаваг ирсэн байна. Бодлогын газрын Дипломат сургалт, судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга Батсуурийн Мөнхбаяр.

Нэр дэвшигч нарын нэрсийг танилцуулъя.

Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гончигзэвэгийн Тэнгэр ирсэн байна. Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Доржраагийн Мөнхтөр ирсэн байна. Монгол Улсаас Бүгд Найрамдах Беларусь Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Байгальмаа ирсэн байна. Бүгд Найрамдах Болгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Авирмэдийн Баттөр ирсэн байна. Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Ганбаатарын Хулан ирсэн байна. Бүгд Найрамдах Герман Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Жагдагийн Оюунбаатар. Оюунбаатар ирээгүй байна уу. Дараагийнх нь Бүгд Найрамдах Египет Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Доньжчимбуугийн Бямбадорж ирсэн байна. Бүгд Найрамдах Итали Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дансрангийн Булган ирсэн байна. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батсүмбэрийн Мөнхжин ирсэн байна. Бүгд Найрамдах Казакстан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Батжаргал ирсэн байна. Киргиз улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дэмчигийн Тэгшжаргал ирсэн байна. Оросын Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дуламсүрэнгийн Даваа ирсэн байна. Бүгд найрамдах Сингапур Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Ганболдын Уянга ирсэн байна. Бүгд Найрамдах Турк Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Очирын Лхагвасүрэн ирсэн байна. Унгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайдаар Нямцэрэнгийн Энхтайван ирсэн байна. Бүгд Найрамдах Франц Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэндийн Мөнх-Оргил ирсэн байна. Бүгд Найрамдах Чех Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батсайханы Болормаа ирсэн байна. Арабын Нэгдсэн Эмират Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Амгалангийн Ананд ирсэн байна. Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лувсанжавын Өлзийт ирсэн байна. Тайландын Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Вашагийн Оюу ирсэн байна. Бүгд Найрамдах Герман Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Жагдагийн Оюунбаатар ирсэн байна. Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Даваахүүгийн Баттөр ирсэн байна.

2025 оны 12 сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Гадаад бодлогын зөвлөх Эрдэнэцогтын Одбаяр танилцуулна. 5 номерын микрофон.

Э.Одбаяр: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье.

Эрхэм хүндэт Улсын Их Хурлын Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамдинсүрэнгийн Даваасүрэнг эгүүлэн татаж, Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гончигзэвэгийн Тэнгэрийг, Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Мижиддоржийн Цэнгэгийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Доржраагийн Мөнхтөрийг, Монгол Улсаас Бүгд Найрамдах Беларусь Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Батсүхийн Баярсайханыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Беларусь Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Байгальмааг, Бүгд Найрамдах Болгар Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Лхагвасүрэнгийн Саяанаг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Авирмэдийн Баттөрийг, Монгол Улсаас Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жигжээгийн Сэрээжавыг эгүүлэн татаж Монгол Улсаас Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Ганбаатарын Хуланг, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бирваагийн Мандахбилэгийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Жагдагийн Оюунбаатарыг, Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Энхтүвшиний Булганыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Доньжчинбуугийн Бямбадоржийг, Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Цэрэндоржийн Нарантунгалагийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дансрангийн Булганыг, Монгол Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Баттөмөрийн Энхсүхийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батсүмбэрийн Мөнхжинг, Монгол Улсаас Бүгд Найрамдах Казакстан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Доржийн Баярхүүг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Казакстан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Батжаргалыг, Бүгд Найрамдах Киргиз Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Содномын Ганхуягийг эгүүлэн татаж, Киргиз Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дэмчигийн Тэгшжаргалыг, Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Өлзийсайханы Энхтүвшинийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дуламсүрэнгийн Давааг, Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Сосорбарамын Энхбаярыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур

Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Ганболдын Уянгыг, Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Гомбосүрэнгийн Мөнхбаярыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Очирын Лхагвасүрэнг, Монгол Улсаас Унгар Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Сайн Сайннямбуугийн Баатаржавыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Унгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Нямцэрэнгийн Энхтайваныг, Монгол Улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Уламбаярын Нямхүүг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэндийн Мөнх-Оргилыг, Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамдины Гансүхийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батсайханы Болормааг, Монгол Улсаас Арабын Нэгдсэн Эмират Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шижээхүүгийн Одонбаатарыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Арабын Нэгдсэн Эмират Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Амгалангийн Анандыг, Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамбажавын Ганболдыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суух Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайдаар Лувсанжавын Өлзийтийг, Монгол Улсаас Тайландын Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Амарсанаагийн Төмөрийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Тайландын Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Вашагийн Оюуг, Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жамсрангийн Бямбасүрэнг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Даваахүүгийн Баттөр нарыг тус тус томилох саналыг Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар хэлэлцүүлж дэмжсэн болно.

Элчин сайд нь Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд суугаа болон хавсран суугаа улс, олон улсын байгууллага даа Монгол Улсыг төлөөлөн ажиллаж, эрх, ашиг сонирхлыг нь хамгаалах, харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, Монгол Улсын хөгжлийн зорилтыг ханган хэрэгжүүлэхэд шаардагдах судалгаа мэдээллийг хийж, төр засгийн байгууллагыг мэдээ мэдээллээр хангах, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, 2 болон олон талын харилцааны асуудлаар яриа хэлэлцээ хийх, гэрээ хэлэлцээр байгуулах, Монгол Улсын иргэн, Монгол Улсын хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг олон улсын эрх зүй болон суугаа орныхоо хууль тогтоомжийн дагуу хамгаалж ажилладгаас гадна тэргүүлж буй Элчин сайдын яамныхаа үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэгтэй байдаг.

Элчин сайдаар томилон ажиллуулахаар нэр дэвшүүлж буй эдгээр албан хаагчид нь төрийн болон дипломат албанд олон жил ажилласан, мэргэжлийн өндөр ур чадвартай, удирдах ажлын дадлага туршлагатай, гадаад хэлний мэдлэгтэй, төрийн болон дипломат албаны хууль тогтоомжийн шалгуурыг хангасан төрийн тусгай албанд ажиллах бүрэн боломжтой гэж Монгол Улсын Ерөнхийлөгч үзэж байгаа болно.

Дээрх орнуудад суух Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшиж байгаа албан хаагчдыг хэлэлцэн зохих шийдвэр гаргаж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Энхтүвшин: Одбаяр зөвлөхөд баярлалаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болон нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу. Нэрсээ өгнө үү. Батсүмбэрэл гишүүнээр тасалъя. Номтойбаяр гишүүн.

Н.Номтойбаяр: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Энэ удаагийн Элчин сайд нарын томилгооны багц бол яах аргагүй Монгол Улсын гадаад дахь нэрийн хуудас болно гэдэг утгаараа бол үнэхээр таалагдаж байна. Олон талаас нь судалж, бараг анх удаагаа шахуу ийм аятайхан томилгоо харж байна. Томилогдох бол нэг тал. Гагцхүү томилогдоод үр дүн гаргана гэдэг бол шал өөр тал байгаад байгаа юм. Тэгэхээр энэ үүднээсээ би зарчмын 1 санал гаргамаар байна. Энэ Байнгын хорооны гишүүддээ мөн Гадаад хэргийн сайд Батцэцэгт бас хандаж хэлэхэд бид ингээд томилоод явуулдаг. Томилогдохдоо үүрэг даалгавар аваад, ам өчиг өгөөд сайн ажиллана гэж амлаад л томилогддог. Гагцхүү эргүүлэн татагдаад, энэ Байнгын хороо дээр ердөөсөө тайлангаа тавьдаггүй. Тэгэхээр энэ тайлангаа тавьдаг энэ жишгийг энэ Байнгын хороо тогтоомоор байна. 4 жилийн дараа томилогдоод ирэх эдгээр Элчин сайд нартай уулзмаар байх юм. Ингээд төдийд томилогдохдоо ийм ийм үүрэг даалгаврууд авч байсан. Очсон газар болгоноо очоод ямар ололт амжилт гаргав. Монгол Улсын хөгжлийн төлөө юу хийж бүтээв гээд асуумаар л байх юм. Үр дүн яаж гаргах вэ.

2 дахь миний хөндөх гээд байгаа зарчим юу вэ гэхээр төрийн айлчлал, төр засгийн төлөөлөл очихоор бүхий л байдгаараа үйлчлээд гүйгээд байдаг. Нөгөө хувийн хэвшил нь очихоор ердөөсөө тоодоггүй. Тэгээд ярвайгаад суучихдаг. Уулздаг ч үгүй, тус дэм болдог ч үгүй. Эцсийн дүндээ энэ хувийн хэвшилд чинь л гадаадад байгаа Элчин сайд нарын дэм тус маш их хэрэгтэй байдаг. Юун дээр хэрэгтэй юм. Чадварлаг боловсон хүчин хэрэгтэй. Гаднын өндөр ур чадвартай мэргэжилтнүүд хэрэгтэй байна. Эсрэгээрээ энэ залуучуудаа тэр бүс нутагт нь очоод сургах хэрэгтэй байгаад байдаг. Тэгэхээр энэ боловсон хүчний бодлого хаана хаанаа маш дутмаг болчихсон, толгой өвчин болчихсоныг бүгдээрээ л мэдэж байгаа. Хувийн хэвшил ч тэр, төрд ч тэр. Тэгэхээр энэ боловсон хүчний бодлого дээр бүр онцгойлон ажилламаар байна.

2-т нь юу вэ гэхээр мэдээж хөрөнгө оруулалт. Хөрөнгө оруулалт гэхээр нөгөө автоматаар уул уурхай гээд байдаг. Тэртээ тэргүй уул уурхайн компаниуд төрийн дэмжлэгтэй, дэмжлэггүй өөрсдийнхөө учрыг олоод явчихдаг. Хүнс, хөдөө аж ахуйн салбар. Саяхан Улсын Их Хурлаас Евроазийн эдийн засгийн хамтын ажиллагааны .../минут дуусав/

Д.Энхтүвшин: 1 минут нэмж өгье. Номтойбаяр гишүүнд.

Н.Номтойбаяр: Энэ хүрээнд зөвхөн тэр Евроазийн бүс нутгийн 5 улсын хэмжээнд биш, бусад улс орнуудаас хүнс, хөдөө аж ахуйн салбартаа энэ техник технологи, чадварлаг боловсон хүчин, хөрөнгө оруулалт гээд бүхий л бололцоог бид нар эрэлхийлж ажилламаар байгаад байгаа юм. Одоо эдгээр улсуудад томилогдож байгаа Элчин сайд нар тухайн улсын чинь хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжил бол бүгд онцлог онцлогоороо дээд түвшиндээ гарчихсан. Тэгэхээр энэ дээр та бүхэн бас онцгойлон ажиллаач ээ.

Тэгээд хамгийн гол нь нөгөө энд ингээд томилогдох болохоороо л баахан л юм ярьцгаадаг. Тэгээд үр дүнг ерөөсөө хөөж ажилладаггүй. Тэгээд аль аль талдаа энэ тал дээр Байнгын хороо, Гадаад хэргийн яам, Элчин сайд нар бүгдээрээ л бас үр дүн гаргахын төлөө эрэлхийлж ажилламаар байна. Тэгээд ажилд нь амжилт хүсье.

Д.Энхтүвшин: Батцэцэг сайд. Энэ томилогдсон Элчин сайд нарын одоо ажлын гүйцэтгэл, дүгнэлт, тайлантай холбоотой асуудлаар хариулт өгөх үү.

Б.Батцэцэг: Номтойбаяр гишүүнд баярлалаа. Тайлангийн хувьд бол би өөртэй чинь санал нэг. Би өөрөө бараг бас тийм саналыг гишүүд, Байнгын хороондоо тавьсан. Энэ жилийн хувьд бид нар оны төгсгөлөөр Гадаад харилцааны яам, одоо хилийн чанадад сууж байгаа 50 дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнүүдийн хийсэн ажил, жилийн хугацаанд гарсан үр дүнгийн талаар тайлан тавих гээд бэлдэж байгаа. Байнгын хорооны Тэмүүлэн даргаас бас манайд үүрэг өгсөн. Энэ жил Элчин сайд нарын тайланг сонсьё гээд. 2022 оноос хойш томилогдож байгаа Элчин сайд нартай гэрээ байгуулахаас гадна зөвхөн саяын дурдсан асуудлууд, хилийн чанад дахь иргэдийн асуудал, худалдаа, эдийн засгийн харилцаа, хөрөнгө оруулалттай холбоотой хийх ажлууд гээд 5 заалттай ийм гэрээг тусад нь сайдтай Элчин сайдаар байгуулаад, тайлангаа хагас жил тутам өгөөд яваад ерөнхийдөө хэвшиж байгаа. Тэгэхээр одоо эргээд ирж байгаа энэ хүмүүсийг томилогдоод явахаар зөрөөд ирэх 23 Элчин сайд байгаа. Тэдний тайланг Байнгын хороон дээр тавиулъя. Тэгээд бас Байнгын хорооныхоо гишүүдтэй уулзуулъя. Энэ бүрэн боломжтой гэдгийг хэлье.

Хувийн хэвшил тоодоггүй асуудал бол сүүлийн жилүүдэд өөрчлөгдөж байгаа. Одоо Элчин сайд нарын тэр угтах, үдэх журам өөрчлөгдсөн. Тэгээд хувийн хэвшлийг дэмжих тал дээр сүүлийн жилүүдэд хэрэгжиж байгаа бүх айлчлалуудаар дагаад бизнес форум явдаг болсон. Илүү бодитой хамтын ажиллагаа, харилцан ашигтай хамтын ажиллагаа руу өөрөө манай Монгол Улсын бодлого чиглэгдэж байгаа болохоор гаднын түншүүдтэй нь уулзуулах, шинэ зах зээл боломжийг нь олгож өгөх, уул уурхайн бус бараа бүтээгдэхүүнийг экспортлох тал дээр нэлээд бодлогын өөрчлөлт гарсан. Энийг өнөөдөр дэвшиж байгаа Элчин сайд нар ч гэсэн тусгайлан үүрэг болгож өгч байгаа. Элчин сайдаар томилогдохоосоо өмнө тодорхой хугацаанд бас айлаас зөвшөөрлөө хүсээд, зарлиг гараад явтлаа бас хэдэн сар болдог. Энэ хугацаанд бол тасралтгүй ийм сургалт зохион байгуулах бүх салбар яамнуудтай уулзалт зохион байгуулдаг ийм тусгайлсан бэлтгэл ажлын төлөвлөгөө гардаг. Энэ хүрээндээ бид нар бас Засгийн газар дээрээ ч гэсэн ярьсан. Ийм бодитой хамтын ажиллагаа өрнүүлэх, Монголын аж ахуйн нэгжүүдээ тэгж байж бараа бүтээгдэхүүн гадагш гаргах энэ нөхцөлийг нь бүрдүүлъя.

2 дугаарт гадна талдаа ер нь сүүлийн 5 жил гадаад харилцааны идэвхжил, олон өндөр дээд хэмжээний айлчлалуудын үеэр юу тохирсон бэ гэхээр бид нар гадаад орчныхоо эрх зүйн орчныг бол нэлээн сайн бүрдүүлсэн гэж үзэж байгаа. Гаднын компаниуд, гаднын улс орнууд манай Монголоос бараа бүтээгдэхүүн, чанар шаардлагыг маань стандартыг нь хангах юм бол тогтвортой нийлүүлж чадах юм бол авахад бэлэн байна гэхихсэн байгаа юм. Тэгэхээр бид нар дотооддоо өөрсдөө бэлдэх, аж ахуйн нэгжүүдээ бойжуулах, бараа бүтээгдэхүүнийг сурталчлах тал дээр илүү идэвх санаачилга гаргах ийм үүрэг бол яалт ч үгүй Гадаад харилцааны яаманд ирсэн. Тэгэхээр энийгээ бид нар хэрэгжүүлэх, энийгээ бас тусгайлан Элчин сайд нартайгаа тохирч явуулна.

Д.Энхтүвшин: Баярлалаа. Энхнасан гишүүн.

Л.Энхнасан: Баярлалаа. Та бүхний энэ өглөөний амар амгаланг айлтгая. Энэ удаагийн томилгоог бас дэмжиж байгаа. Яагаад гэвэл маш олон төрийн болон дипломат албаны туршлагатай, удирдах ажлын ур чадвартай, гадаад хэлний мэдлэгтэй ийм олон хүмүүс нэр дэвшиж байна. Тэгээд бас олон эмэгтэйчүүд бас

Элчин сайдаар томилогдож байгаад бас баярлалаа. Ингээд нэр дэвшиж байгаа хүмүүсээс бүгдээс нь асуух асуулт байна. Тухайн дэвшиж байгаа улсдаа яг онцгойлон ямар ажил хийх вэ. Харилцаанд ойрын 5 жилд ямар түвшинд хөгжүүлнэ гэж бодож байгаа вэ. Энэ талаар товчхон.

Тэгвэл тухайлан ялангуяа Австрали улсын харилцаа бол чухал байгаа. Орос, Казахстан, Лаос, Франц гэсэн улсуудаас асууя.

Д.Энхтүвшин: Саяын улсууд микрофонд ойрхон сууж байя. 6 номероос эхэлье.

Д.Даваа: Эрхэм Байнгын хорооны дарга эрхэм гишүүдийн өглөөний амар амгаланг айлтгаж мэндчилье. Энхнасан гишүүний асуултад маш товчхон хариулъя гэж бодож байна. Мэдээж 2 улсын харилцааны тухай бол та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Хугацаагүй иж бүрэн стратегийн түншлэлийн гэрээтэй 2019 онд байгуулагдсан. 2019 онд манай парламент 2020 оны 7 сард Оросын холбооны парламентын дээд, доод танхимаар батлагдаад бүрэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ийм гэрээтэй ийм орон учраас бол энэ харилцааг хөгжүүлэх тал дээр бодитой энэ гэрээнд тусгагдсан 21 зүйл, заалт бүхий ийм гэрээтэй орон байгаа. Тэгээд үүнийг яг бодитойгоор ажил хэрэг болгох энэ чиглэлд бол мэдээж анхаарч ажиллана. Дээрээс нь бол миний очоод хийх хамгийн түрүүний ажил Засгийн газрын хуралдаан дээрээс бидний хэдэн сайд нарт тухайлан өгсөн нэг үүрэг байгаа. Тэр бол сая 12-ны өдөр Монгол Улсын Их Хурлаар соёрхон батлагдсан Евроазийн эдийн засгийн холбоотой чөлөөт худалдааны төв хэлэлцээр хийсэн. Соёрхон баталсан энэ гэрээ хэлэлцээрийг тухайн тухайн орнуудын парламентуудаар соёрхон батлуулахад онцгой анхаарч, чармайлт гаргаж, түлхэц өгч ажиллах гэсэн тийм үүрэг өгчихсөн байгаа.

Оросын Холбооны Улсын хувьд бол Төрийн ДУМ 16-ны өдөр энэ гэрээг Соёрхон баталсан. Ийм мэдээ ирсэн. Дээд танхим буюу Совет Федерации ойрын хугацаанд оруулна гэсэн мэдээтэй байгаа. Хариулж дууслаа.

Д.Энхтүвшин: Баярлалаа. 1 номерын микрофон. Нэр, дэвшиж байгаа улсаа хэлээрэй.

Г.Тэнгэр: Австралийн Холбооны Улсад нэр дэвшиж байгаа Тэнгэр байна. Энхнасан гишүүний асуултад хариулъя. Австрали Улс маань бол онцлогтой. Та бүхэн бас мэдэж байгаа. Тэгэхдээ би товч хариулъя гэж бодож байна. Хамгийн их монголчууд амьдардаг, 3-д орж байгаа орон. 22 мянган Монгол иргэд байдаг. Тийм учраас бид нар бас хувийн хэвшлийн асуудал Номтойбаяр гишүүн хөндөж байна. Ерөнхийдөө бол энэ ажиллаж, амьдарч, сурч байгаа Монгол иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах, консулын үйлчилгээг бол чанартай үзүүлэх гэдэг дээр бас анхаарч ажиллая гэж бодож байна.

2-т нь бол саяхан энэ намар Австралийн амбан захирагч Монгол Улсад айлчилсан. Буцаад Монгол Улсын Ерөнхийлөгчийг урьсан урилгатай байгаа. 2 жилийн дараа бол энэ 2 улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ой болно. Энэ хүрээнд ёслол төгөлдөр тэмдэглэе гэж бодож байна. Тэгээд тэр хүрээндээ бас Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлалыг зохион байгуулах ийм зорилготой байна. Ер нь бол Ерөнхийлөгчийн гадаад бодлого бол одоо Төв Ази руу чиглэж байсан бодлого бол үргэлжлээд, мөн нэмэлтээр Энэтхэг, Номхон далайн орнуудтай харилцаа хамтын ажиллагаа хөгжүүлэх чиглэлээ бол өгсөн байгаа. Энэ

тал дээр бас ажиллая гэсэн бодолтой байна. Хөрөнгө оруулалтын хувьд эдийн засгийн харилцааны хувьд бас Австралийн уул уурхайн компаниуд бол Монголд нэлээн хөрөнгө оруулалттай. Нийтдээ 450 сая долларын хөрөнгө оруулалт бол орсон байдаг. Үүнтэй холбоотой 2 улсын харилцаа, боловсон хүчин бэлтгэх, мөн нэмэлт хөрөнгө оруулалтыг татах энэ чиглэлээр бол тодорхой тодорхой ажлуудыг маш прагматик хэлбэрээр хийж хэрэгжүүлэе гэсэн бодолтой байгаа. Баярлалаа.

Д.Энхтүвшин: Баярлалаа. 2 номер Батжаргал дарга.

Г.Батжаргал: Та бүхний энэ өглөөний амар амгаланг айлтгая. Батжаргал. Бүгд Найрамдах Казакстан Улсад Элчин сайдаар томилогдохоор горилогч. Юуны өмнө бол Евроазийн эдийн засгийн холбоотой байгуулсан чөлөөт худалдааны хэлэлцээрийг Казакстан Улсаар соёрхон батлуулах, Казакстаны парламентаар соёрхон батлуулах ажлыг бол хамгийн түрүүнд хийж, гүйцэтгэнэ гэж бодож байна.

2-т нь бол мэдээж Төв Азийн 5 улс бол манай гадаад бодлогод чухал. Сүүлийн жилүүдэд Төрийн тэргүүний хэмжээнд хийсэн айлчлал байна. Төв Азийн орнуудад хийсэн айлчлал байна. Тэр орнуудаас манай улсад хийсэн ажлууд байна. Тэгээд эднийг бол цааш нь үргэлжлүүлэх, тэгээд Төв Азитай ямар бодлоготой Монгол Улс цааш нь харилцах вэ гэдэг дээр бол Гадаад яамандаа болон төр засагтаа бодлогын түвшинд бол дэм тус болно гэж бодож байна.

3-д нь бол иргэд хоорондын харилцаа. Та бүхэн мэдэж байгаа Казакстан Улсад Монгол иргэд бол тэнд амьдарч, аж төрж, сурч байна. Тэгээд тийшийгээ бол хөдөлгөөн нэлээн нэмэгдсэн. Сүүлийн жилүүдэд 22-25 мянган иргэд нааш цаашаагаа айлчилж байна. Казахстан бол Төв Азидаа бол нөлөө бүхий улс орон Улс орны жишээлбэл эдийн засаг нь бол Казахстаны эдийн засгийн өсөлт, гадаадын хөрөнгө оруулалт бол маш эрчимтэй хөгжиж байгаа. Одоогийн байдлаар 2024 оны тоогоор бол 300 тэрбумын ам.долларын эдийн засагтай улс орон. Тэгэхээр бол энэ улсаас гадаадын хөрөнгө оруулалтыг хэрхэн сайн татаж байна вэ. Ялангуяа жишээлбэл уул уурхай, эрчим хүч, тэгээд дээр нь чухал хэрэгцээт энэ металлын чиглэлээр бол маш их ажил хийгдэж байгаа.

4-д нь бол мэдээж энэ бизнесийн харилцаа дээр би бол буцаад манай хувийн хэвшлийнхэнд, манай бизнесийн байгууллагуудад хэрхэн туслах талаар бас өөрийнхөө бодол, санаа тэгээд бусад санааг дэвшүүлж ажиллана гэж бодож байна. Товчхондоо ийм. Баярлалаа.

Д.Энхтүвшин: Баярлалаа. 3 номер Мөнх-Оргил сайд. Даваахүүгийн Баттөр 1 номер луу солиод суучих. 3 номерын микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Миний хувьд томилолтын 4 жилийн хугацаанд Монгол Францын харилцааг стратегийн түншлэлд хүрэх ёстой юм байна л гэж ойлгож байгаа. Одоогийн байдлаар стратегийн түншлэлийн харилцаатай АНУ, Япон, Герман, Солонгос, Казахстан, Турк, Энэтхэг, Итали гээд 8 улс байгаа. Энэ 4 жилийн хугацаанд Монгол, Францын харилцааг энэ 8 улсын түвшинд хүрэх ёстой юм байна. Үүнийг хийхийн тулд юуны өмнө цөмийн эрчим хүчний салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх, тухайлбал Монгол Улсын Засгийн газар Орано компанийн хооронд байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээг ажил хэрэг болгох, мэдээлэл харилцаа холбооны салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх, тухайлбал Францын хөнгөлөлттэй зээлээр Монгол Улсын өөрийн холбооны хиймэл дагуулыг хөөргөх

ажлыг хийж гүйцэтгүүлэх, Франц Улсад сурч байгаа Монгол оюутнууд, мэргэжилтнүүдийн тоог нэмэгдүүлэх, 5-д нь 156 сая долларын хэмжээтэй байгаа жилийн худалдааны эргэлтийг наад зах нь 1 тэрбум долларт хүрэх ёстой юм байна. Энэ ажлыг хийж чадвал Монгол, Францын харилцаа стратегийн түншлэлд хүрэх юм байна гэж бодож байгаа.

Д.Энхтүвшин: Баярлалаа. 1 номер Баттөр нэр дэвшигч.

Д.Баттөр: Эрхэм гишүүдийн амрыг эрж мэндчилье. Энхнасан гишүүний асуултад хариулъя. Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад Элчин сайдаар томилогдохоор горилогч Даваахүүгийн Баттөр байна.

Лаос, Монголын харилцаа 1962 оноосоо хойш дипломат харилцаа тогтоосноос хойш эдүгээ найрсаг харилцаа, хамтын ажиллагаа, харилцан бие биеэ дэмжиж, харилцан ашигтай байх үндсэн зарчим дээр ажилладаг. Энэ хамтын ажиллагааны хүрээнд томоохноос нь дурдах юм бол ерөнхийдөө 2 улсын оюутан солилцооны хөтөлбөрүүд байна. Өнөөгийн байдлаар 59 Лаос оюутан Монголд суралцаж байна. Монголын талаас 14 оюутан суралцаж байна. Бас онцлох 1 зүйл бол Монгол, Лаосын Найрамдал эмнэлэг байдаг. Монгол Улсын Засгийн газар, Монголын ард түмний хөрөнгөөр бий болсон. Лаосын талаас бол нэлээдгүй хөдөө аж ахуй зонхилсон ийм улс орон юм билээ. Тэгэхээр эдгээр 3 чиглэл дээр бол бас онцгойлон харилцаа, хамтын ажиллагааг улам дэмжиж ажиллана гэсэн бодолтой байна.

Яг онцгойлон бас ойрын жилд хийх зүйл гэх юм бол Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс хойд талаараа Бүгд Найрамдах Хятад Ард Улстай төмөр зам болон авто замын боомтоор холбогдсон юм байна лээ. Үүгээр бол тээвэрлэлт хийж Монгол Улс Хятад улсаар дамжаад тээвэрлэлтийн боломж илүү нэмэгдэнэ. Энэ тал дээр илүү боломжийг хайж ажиллана гэж бодож байна. Мөн манай 2 улс Агаарын харилцааны хэлэлцээр байгуулагдсан. Тэгэхээр бол china southern airlines, lao airlines гээд эдгээр улсуудын interline гэрээнүүдийг бол судалж үзэж ийм гэрээнүүд байдаггүй бол хийгдэнэ гэсэн ийм бодолтой байж байна. Үүгээр бол ачаа шууд дамжиж, үүнээс улбаалсан зорчигч, ачаа тээврийн урсгал нэмэгдэж, 2 талын хамтын ажиллагаа бас илүү нэмэгдэх бололцоо бий. Үүнийг эрэлхийлж ажиллана гэж бодож байна. Баярлалаа.

Д.Энхтүвшин: Баярлалаа. Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Элчин сайдын ажил бол олон хүний хардгаар шагнал гэж харагддаг. Тэгэхдээ энийг бас хариуцлага, үүрэг, Монгол Улсынхаа өрсөлдөх чадварыг олон улсын тавцанд илүү ихээр гаргаж чадах эдийн засгийн боломжийг эх орон руугаа татах ийм хүндтэй бөгөөд асар хариуцлагатай, 1 талаас эмзэг үүрэг гэж харж байгаа. Тэр утгаараа бол протоколд үлдээж би 21 хүнээс юм асуухаас илүүтэйгээр зарчмын хэдэн байр суурийг та бүхэнд хэлмээр байна. Гадаад бодлогын үзэл баримтлалын 21.6 дээр гадаад худалдааг эдийн засгийн өсөлт, хүн амын эрэлт хэрэгцээг хангахад чиглүүлж, үр ашгийг нь дээшлүүлэх, гадаад худалдааны тааламжтай нөхцөлүүдийг олгох замаар өөрийн бараа үйлчилгээний зах зээлийг тэлэх нөхцөлийг бүрдүүлэх. Энэ үүргийг бол Элчин сайдууд маань бас гар бие бүхий л боломжоо дайчилж ахиулахын төлөө явах ёстой.

21.7 дээр энэ бизнесийн таатай орчныг бүрдүүлж, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг тэнцвэртэй нэмэгдүүлэхийн зэрэгцээ үндэсний аж ахуйн нэгж гадаад хөрөнгө оруулах, дэлхийн санхүү, хөрөнгийн зах зээлд нэвтрэх нөхцөлийг

бүрдүүлэхэд эрмэлзэх гэж байгаа. Герман жишээлбэл Монголын харьцааг харахаараа 12 сая долларыг харьцах нь 170 сая долларын харьцаатай байгаа юм. Манайх тэндээс 175 сая долларын импорт хийгээд, тэднийх бол манайхаас 12 сая. Тэгэхээр энэ тоог яаж хооронд нь ойртуулах вэ гэдэг шиг улс болгон дээр эдийн засгийн харилцаа, хөрөнгө оруулалтыг ахиулах дээр анхаармаар байгаа.

Дараагийн чухал зүйл нь болохоор энэ орчин үеийн шинжлэх ухаан, технологийн үндэсний чадавхыг сайжруулах, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасгахад дөхөм үзүүлэх нь шинжлэх ухаан, технологийн гадаад харилцааны бодлогын зорилго гэж байгаа. Одоо энэ хиймэл оюун бүтээмж маш өөр түвшинд хүрчихсэн байгаа. Энэ дээрээ бол бид нар маш тодорхой алхмуудыг хийх зайлшгүй шаардлагатай. Тийм учраас суугаа орон орон болгоноосоо ийм боломж бололцоонуудыг эрэлхийлэх дээр та бүхэн маань бас онцгой анхаараарай гэж хэлмээр байна.

Энэ 25.2 дээр боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг олон улсын жишиг шаардлагад ойртуулан сайжруулах энэ тал дээр ахиц дэвшилд хүрсэн улсуудын туршлагыг судалж, хэрэгжүүлэхэд дөхөм үзүүлэх гэж байгаа юм. Манай улсын энэ өрсөлдөх чадварыг унагааж байгаа гол шалтгаануудын 1 бол боловсролын салбарын хүнд нөхцөл байдал шүү дээ. Foss гэж байгууллага байдаг. forum of small states (foss) тэндээс гаргасан 37 орны судалгаагаар бол 10-аас доош сая хүн амтай улс орнуудын хөгжлийн номер 1 хөдөлгүүр нь юу вэ гэхээр ерөөсөө боловсролын салбарын реформ байдаг. Энийг бас яг олон улсын харилцаа, гадаад бодлоготой гардан хэрэгжүүлж ойртуулах хүмүүсийг нь бол та бүхэн гэж харж байгаа.

Энэ гадаад бодлогын үзэл баримтлалын 27.3 дээр байгаа иргэд гадаадад зорчих эрх зүйн таатай орчин нөхцөл бүрдүүлэхийг эрмэлзэх гэж байгаа. Үүнийг бас гардан хэрэгжүүлэх хүмүүс бол та нар. Нэр дэвшигчдийн дунд Энэтхэг рүү томилогдож байгаа Лувсанжавын Өлзийт гэж нэр .../минут дуусав/

Д.Энхтүвшин: Эрдэнэболд гишүүнд 1 минут нэмж өгье.

С.Эрдэнэболд: Тэгээд энэ хүнийг би танихгүй. Гэхдээ энэ хүний аавыг Монголын ард түмэн бас хүндэтгэдэг. Бичгийн их хүн Чой.Лувсанжав гэж хүн. Энэ хүний хэлсэн үгийг эш та бүхэндээ хэлмээр байна. Хүн чанаргүй хүнд өндөр боловсролыг эзэмшүүлбэл босоо ороолонд алтан шүд хийгээд босгохтой адилхан гэж. Мэдээж өндөр мэдлэг боловсролтой, дипломат албаны туршлагатай ч гэсэн та бүхэн байгаа суугаа газар, орон болгондоо Монгол хүмүүсдээ эх орон нь болно. Еврейчүүдийн айхтар үг байдаг шүү дээ. Еврей хүн Еврей хүндээ эх орон гэж. Монгол хүн Монгол хүндээ эх орон байдаг тэр цэг голомт бол Элчин сайдын яам байдаг. Тэр утгаараа бол бүхий л талаар эрмэлзэж хичээж ажиллаарай. Чадвар бол нэмэгдэхүүн, хандлага бол үржигдэхүүн байдаг учраас Монголоо гэсэн халуун сэтгэлээр өргөсөн тангарагтаа үнэнч, хуулийн хүрээнд эх орныхоо нэр төрийг өндөрт өргөж, асар хариуцлагатай ажиллаарай гэдгийг та бүхэнд хэлье. Харьцангуй чамбай нэр дэвшигчид орж ирж байна. Тийм учраас Монгол Улсын гадаад бодлогын 1 цонх, 1 нүүр царай нь бол та нар шүү гэдгийг хэлмээр байна.

Д.Энхтүвшин: Эрдэнэболд. Гишүүн үг хэллээ. Наранбаяр гишүүн асуулт асууна.

П.Наранбаяр: Баярлалаа. Миний зүгээс бол асуулт байхгүй. Зүгээр үг хэлнэ.

1 дүгээрт мэргэжлийн ийм сайн улсууд орж ирж байна гэж харж байна. Заримтай нь хамт ажиллаж, заримтай нь хамт бас гар нийлэн ажиллаж байсан ч хүмүүс ч байна. Сайн таних мэдэх хүмүүс ч байна, танихгүй хүмүүс ч байна. Гэхдээ энэ бол яг ингээд намтар юмыг нь харахаар бүгдээрээ ийм мэргэжлийн дипломат албанд олон жил зүтгэсэн ийм хүмүүс байна. Тэгэхээрээ үр дүн илүү сайн гарах болов уу гэж найдаж байна. Энэ утгаараа 2, 3 зүйл хэлье гэж бодлоо.

1 дүгээрт олон улсын өнөөдрийн дэг их өөрчлөгдлөө. Трамп гарч ирснээрээ бол өмнө байсан сургуулиуд бол өөр болж, олон улсын харилцаа бол их хүчинд тулгуурласан реалист маяг руу ороод байгаа юм. Ийм хандлагатай болчихсон ийм үед өнөөдөр жишээлбэл ДХБ-ын зарчмыг Америк өөрөө задалж эхэллээ шүү дээ. Энэ нөхцөлд тарифын хэлэлцээ юмнууд бие биетэйгээ тулсан, мөргөлдсөн, тулгарсан ийм нөхцөл дунд манай дипломат алба бол 1 дүгээрт эдийн засгийн эрх ашгийг л тавьдаг энэ юм руугаа илүү хүчтэй орох шаардлагатай байна гэж харж байна.

Би ганц 2 жишээ хэлье. Энэ Киргизэд Монгол Улсын Ерөнхийлөгч айлчлах үеэр миний бие бүрэлдэхүүнд нь орж очсон. 10 гаруй Монголын компанийг тийш нь оруулчихсан байсан. Тэдгээр нь нэр хүнд өндөртэй байна лээ. Тэгэхээр зэрэг ийм тодорхой тодорхой үр дүнгүүдийг гаргахаар бас ажиллах байх гэж найдаж байна. Мөн Чехэд очиход бол Чехийн Ерөнхийлөгч манай улсын салшгүй нэг хэсэг болж бидний хөгжилд бидний сайн сайхан байдалд хувь нэмрээ оруулж байгаа Чехэд оршин сууж байгаа Монголын иргэдэд тусгайлан талархал илэрхийлж үг хэлж байсан. Энэ бас их бахархууштай санагдсан. Юу вэ гэхээрээ бас тэнд байгаа Элчин сайдын яам бол нэлээн Монгол иргэдтэйгээ ойр, тэрийгээ дэмжих тал дээр бас тодорхой ажлууд хийгдсэн юм байна гэж харж байсан. Ийм учраас мэдээж улс төрийн харилцаа төрийн харилцааг бол та бүхэн авч явна. Нөгөө талдаа иргэдээ дэмжих, хувийн хэвшлээ дэмжих, энэ тал дээр бас сайтар ажиллаарай гэж хүсэж байна. Одоо ингээд Евроазийн одоо эдийн засгийн хэлэлцээрт Монгол Улс соёрхон баталж сая нэгдэн орж байна. Тэгэхээр энэ дээр бид бол үүнийг зах зээл гэж харж байгаа. Ийм учраас энэ зах зээлийг тэлэх дээр бас ялангуяа үүнтэй хамаатай улс орнуудад очиж байгаа Элчин сайдууд бол онцгой анхаарч ажиллана байх гэж найдаж байна.

Эцэст нь хэлэхэд бол би Австрали улсад очиж байгаа Элчин сайдаас хүсэхэд Австрали улс саяхан бас энэ өсвөр насны хүүхдийн нийгмийн сүлжээнд орох энэ хуулийг бол хязгаарлах тухай энэ хуулийг гаргасан. Энэ хууль хэрхэн хэрэгжиж байгаа тал дээр бидэнд мэдээлэл ирүүлээрэй. Бид бас ажлын хэсэг илгээнэ. Тэр дээр сайхан тусалж ажиллаарай. Энэ дээр бас ... 1 минут авчихъя. Хурал даргалагчаа.

Д.Энхтүвшин: Наранбаяр гишүүнд 1 минут нэмж өгье.

П.Наранбаяр: Тэгэхээр энэ дээр онцгой анхаарч бас ажиллахыг хүсэж байна. Бид бас энэ улс орнуудын өнөөдрийн харилцаа дотор, ялангуяа үндэстэн дамнасан корпорац болох энэ SNS орчныг бий болгочихсон энэ компаниудтай дундаж хөгжилтэй болон хөгжиж буй орнууд хэрхэн харьцах вэ гэдэг энэ олон улсын дэг журам гарч магадгүй. Ер нь бол НҮБ-ын тогтоол ч гарч магадгүй гэж харж байгаа юм. Ингээд энэ SNS дэх орчинд хүүхдийг хамгаалах энэ хуулиудыг бол улс орнууд гаргаж байгаа ийм үед бас тантай бас мэдээлэл солилцож ажиллана гэж бодож байна.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн чиглэлээр бас энэ Сингапурын сайн туршлагуудыг бидэнд бас мэдээлэл болгож ирүүлээрэй гэж хүсэж байна. Энэ чиглэлээр бас бид хүмүүс илгээж ажиллуулна. Яагаад гэвэл сургууль, цэцэрлэгийг барих ажлууд бол 3 жилээс дээш байгаад байгаа. Төр дангаараа барихаар. Хувийн хэвшлийг оролцуулж энэ хугацааг нь богиносгох гэх мэт ийм сайн туршлагуудыг бас судлах ийм шаардлагатай байгаа. Тэгээд өнөөдөр энд хүрэлцэн ирсэн мэргэжлийн бүх дипломатууддаа энэ Элчин сайдаар томилогдохдоо нэр дэвшсэн хүмүүстээ амжилт хүсье. Дэмжиж байгаа.

Д.Энхтүвшин: Мөнхбат гишүүн.

Ц.Мөнхбат: Та бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе. Элчин сайдаар томилогдох гээд нэр дэвшиж байгаа нэр дэвшигчдийг бол дэмжиж байгаа. Тэгээд яах вэ, энэ удаагийн томилгоог бас олон гишүүд хэлж байх шиг байна. Бас их мэргэжлийн байдлыг нь харсан, төрийн алба болон улс төрийн алба, дипломат албандаа олон жил мэргэшсэн ийм байдлаар ажилласан ийм хариуцлагатай хүмүүсийг томилж байна гэж бодож байна. Тэр дундаа би энэ Гунаажавын Батжаргал даргыг бас Элчин сайдаар томилогдож байгаад их баяртай байна. Тэгээд өмнө тэр Австрид Элчин сайд байх үед нь бид нар бас очиж ажиллаж байхад ажилдаа хариуцлагатай, ер нь бас их сэтгэлтэй ийм хүн байдаг юм уу даа гэж ингэж анзаарч байсан. Тэгээд дахиад Элчин сайдаар явж байгаа юм байна. Ер нь манай Элчин сайд улс орноо төлөөлөөд Элчин сайдаа явж байгаа хүмүүс бол их л сэтгэлтэй хүмүүс л байх ёстой юм шиг надад бол санагддаг. Мэдээж мэргэжлийн ур чадвар, хэл усны боловсрол, олон юм байлгүй л яах вэ. Тэгэхдээ их сэтгэлтэй хүмүүс байх ёстой юм шиг ингэж санагддаг юм. Тийм учраас би цохож хэлж байгаа нь энэ.

Тэгээд Батцэцэг сайдаас 1 юм асуух гэсэн юм. Ер нь энэ элчин сайд томилогдоход дипломат албанд насны босго гэж байдаг уу гэдэг нэг ийм асуултыг би сонирхоод асууж байгаа юм.

2 дугаарт нь энэ НҮБ-ын тэр төлөөлөгчийн газар Нью-Йоркт байдаг. Тэн дээр тэр цэргийн атташе Болор генерал дээр орон тоо нэмж өгөх асуудал ямар хэмжээнд явж байгаа вэ гэдэг асуултыг бас дахиад тавья. Тэгээд би яагаад энийг дахин дахин асуугаад байгаа гэхээр үнэхээр бас тэнд ажиллаж байхад бол нөхцөл байдал нь амаргүй байсныг мэдэрсэн учраас би энэ дээр бас анхаарал тавиад дахин дахин ингээд асуугаад байгаа юм. Тэгээд ийм 2 асуултыг бас Батцэцэгээс сайдаас асуучихъя.

Тэгээд ер нь бол нийт нэр дэвшигчдийг бүгдийг нь дэмжиж байна. Тэгээд их мундаг туршлагатай улс төрийн ч тэр, дипломат албандаа ч тэр, ер нь энэ гадна дотнын том том байгууллагуудад бас ажиллаж байсан ийм хүмүүс байгаа юм байна. Энэ Чех руу явж байгаа энэ Батсайханы Болормаа гэдэг хүн, Вьетнам руу явж байгаад тэр Ганбаатарын Хулан дарга гээд сая бас өнгөрсөн 1 жилийн хугацаанд 2, 3 гадаад арга хэмжээнүүдтэй ажиллаж байхад бас их мундаг ажиллаж байсан ийм хүн ингэж ингэж боддог юм. Тэгээд нэр дэвшигчдэдээ амжилт хүсье. Баярлалаа.

Д.Энхтүвшин: Батцэцэг сайд хариулъя. Батцэцэг сайдын микрофоныг нээе.

Б.Батцэцэг: Мөнхбат гишүүндээ баярлалаа. Бас урмын сайхан үг хэллээ. Манай дипломат албанд насны хязгаар ер нь яах вэ бас салбарын онцлог байдаг. Ер нь олон улсад насны хязгаар тавьдаггүй, тухайн орны харилцааг мэргэшсэн, улс орондоо хэрэгтэй элчин сайд нараа бас сунгах, үргэлжлүүлэн ажиллуулах ийм

жишиг байдаг. Манай өнөөдрийн нэр дэвшигчид дотор бол Монгол Улсын хуулиар тэтгэврийн насанд хүрсэн хүн бол байхгүй. Дандаа 65-аас доош насны хүмүүс байгаа.

2 дахь асуудлын хувьд болохоор манайх Нью-Йоркт орон тооны хязгаартаа баригдаад, Болор генерал бол өнөөдөр цэргийн атташегийн хувьд ганцаараа орон тоон дээр ажиллаж байгаа. Бусад орны жишиг бол яах вэ, мэдээж доороо 2, 3 хүнтэй ажилладаг. Тэгэхээр ирэх жилийн төсөв дээр төсвийг нь тавьсан байгаа. Энэ жилийн хувьд бол орон тоо нэмэх ямар ч боломжгүй байгаа учраас Батлан хамгаалах яамтай зөвшилцөөд, өөртэй нь зөвшилцөөд, тэгээд ирэх жилийн төсөв дээр 1 орон тоо нэмж, харьяанд нь хүн ажиллуулахаар болсон байгаа гэдгийг хэлье.

Д.Энхтүвшин: Эрдэнэбүрэн гишүүн.

Р.Эрдэнэбүрэн: Өдрийн мэнд хүргэе. Сөрөг хүчний гишүүний хувьд бол Засгийн газарт зарим зүйлүүд дээр, олон зүйл дээр шүүмжлэлтэй хандаж байгаа. Гэхдээ энэ гадаад харилцаа бас болж байгаа, зөв явж байгаа зүйлийг бол хэлэхээс өөр арга байхгүй. Сүүлийн жилүүдэд бол манай энэ гадаад харилцаа бол их сайн явж байгаа гэж ингэж үзэж байгаа. Ялангуяа дайн тулаантай, хүнд хэцүү байгаа нөхцөлд бол баланс их сайн барьж, харилцаа явж байгаа гэж ингэж харж байгаа. Маш олон улстай бол өндөр дээд түвшний айлчлалууд хийгдэж байна,. Ирж байна, очиж байна. Маш сайн зохион байгуулж байгаа. 1 хэсэг бид нар өндөр түвшний айлчлалууд хэчнээн төгрөгийн зээл тусламж авч ирэв гэдгээр дүгнэдэг байсан бол одоо бол дандаа харилцан ашигтай байх, яавал харилцан ашигтай байх вэ, хамтын ажиллагаа гэдэг энэ чиглэл рүү бол гүн бат орсон байгаа. Тийм учраас бас энэ чиглэлээр сайн ажиллаж байгааг нь хэлэх хэрэгтэй.

2-т 1 чухал зүйл бол дипломат дугаар ашиглаж тамхи зөөдөг, янз бүрийн хэрэг төвөгт ордог ийм зүйл бол их байсан. Одоо бол сүүлийн жилүүдэд сонсогдохоо больсон. Энэ бол маш чухал зүйл болсон гэж ингэж бодож байгаа.

3-д бол энэ удаагийн томилгоо бол бараг 100 хувь шахуу мэргэжлийн хүмүүс орж ирж байна гээд ер нь бусад зөвхөн Их Хурлын гишүүд биш, олон нийт ч гэсэн их сайн хүлээж авч байх шиг байна. Тийм учраас бас их зөв зүйл боллоо. Би ч гэсэн миний мэдэж байгаагаар бол манай Баттөр сайд байна, Мөнхжин гээд залуу байна. Италид очиж байгаа Булган байна. Мөнх-Оргил сайд, Батжаргал гээд миний мэдэх дандаа л мэргэжлийн гадаад яамны л хүмүүс байгаа харагдаж байна.

4-д бол одоо бид нар 1 зүйлийг цаашдаа ярьж, хэлж явах хэрэгтэй юм шиг байгаа юм. Дандаа л 1 визээс чөлөөлөх гэдэг ийм л зүйл яриад, 1 сайн хүн очиж яриад визээс чөлөөлчихдөг юм шиг. Одоо манай Засгийн газрын зарим гишүүд бол ялангуяа энэ Солонгосын визийг зохицуулж байна, шийдэх гэж байна, шахаж байна гээд ингээд яриад байгаа. Ер нь юу юм билээ шүү. Хүн очиж ярихаасаа илүү бид нарын өөрсдөө ДНБ-ээ хэд болгосноос л шалтгаалах юм байна лээ. Автоматаар. Солонгосын бас 1 хүнтэй уулзаад асууж байсан. Энэ Казахстаныг яагаад визгүй болгочихсон юм бэ гээд. 1 хүнд ноогдох ДНБ нь 10 мянга болсон. Тэгээд л автоматаар визгүй болсон. Тийм учраас манай Элчин сайд нар ч гэсэн тэр дотроо, гаднаа бүгдээрээ яаж ДНБ-ээ өсгөх вэ л гэдгээ л ярьж байх хэрэгтэй. Ийм л цаг хугацаа болчихоод байгаа юм. Тэрнээс ингээд л сайн Элчин сайд очоод л визгүй болгодог тийм юм бол байхгүй байх. Тэгээд одоо бид нарын анхаарах 1 чухал зүйл бол .../минут дуусав/

Д.Энхтүвшин: Эрдэнэбүрэн гишүүнд 1 минут нэмж өгье.

Р.Эрдэнэбүрэн: Маш олон газраас зээл авчихсан. Зээлийн хэрэгжилтүүд болбол муу байгаа. Хий баахан хүү төлдөг ийм нөхцөлтэй явж байгаа шүү. Тэгээд энэ очиж байгаа орнуудтай холбоотой санхүүгийн байгууллагуудаас янз бүрийн зээл авчихсан. Тэгээд тэрний хэрэгжилтийг бол их анхаарч ажиллах хэрэгтэй байх гэж ингэж бодож байна.

5-д бол бид нар хөрөнгө оруулалт байхгүй. Хөрөнгө оруулалт ерөөсөө ирэх онд бол Францын уранаас өөр юм байхгүй ингээд явж байгаа. 1 их олон зээлтэй, зээлээ хэрэгжүүлж чаддаггүй. Тийм учраас бид нарын ДНБ-ээ өсгөх юм чинь ерөөсөө хөрөнгө оруулалт дээр л тогтох гэж байгаа. Тэгээд одоо бол бид нарт гадаадад ямар нэгэн улстай засаглалын асуудлаар ч юм уу, шашны асуудлаар ч юм уу болохгүй, бүтэхгүй байгаа 1 ч улс байхгүй. Бүгдээрээ бол хөрөнгө оруулалт, эдийн засгийн харилцаагаа сайжруулах ийм л шаардлагатай ийм үе дээр явж байгаа .../минут дуусав/

Д.Энхтүвшин: Эрдэнэбүрэн гишүүнд дахиж 1 минут нэмж өгье.

Р.Эрдэнэбүрэн: 6-д энэ харилцааг нь бас жоохон гадарладаг улс бол Турк байгаа. Туркт бол маш сайн хүн томилогдлоо гэж харж байна. Турк, Монголын харилцаа бол нэг хэсэг тэр багш нарын асуудлаас болоод жоохон хөрж байгаад буцаад сайжирч байгаа. Сая бол Ерөнхийлөгчийн хэмжээний айлчлалууд болсон. Одоо дахиад зөрөөд ирэх байх. Улс төрийн хувьд бол асуудалгүй болж байгаа. Турк бол 2 онцлогтой улс байгаа.

1 дүгээрт бол Европын холбоонд элсэнэ гэж олон жил бэлдээд, бүх стандарт бүх технологи юм нь бол Европ болчихсон.

2-т бол Турк өөрөө энэ Дундад Азийн, ойрх Дорнодын булангийн орнуудын тэр их мөнгө бол Туркээр дамжиж манайд орж ирэх тийм боломжтой харагдаж байгаа. Тийм учраас яг ийм хөрөнгө оруулалт, санхүү мэддэг энэ чиглэлээр олон жил ажиллачихсан ийм хүнийг Батцэцэг сайд яаж олж тавьсныг нь мэдэхгүй байна. Маш нүдээ олсон .../минут дуусав/

Д.Энхтүвшин: Баярлалаа. Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: Нэр дэвшигчдийн материалтай танилцсан. Ер нь сонголт их оновчтой. Ахмадууд, залуучууд, ялангуяа Гадаад харилцааны яамдаа ажиллаж, туршлагажсан ийм мэргэжлийн хүмүүсийг сонгож оруулсан нь их ач холбогдолтой байна.

Дээр нь 21 нэр дэвшигчийн 7 нь эмэгтэй нэр дэвшигч байна. Үүгээрээ бас онцлог болж өгч байна. Өмнө нь гадаад харилцааны сайдаар ажиллаж байсан, дэд сайдаар ажиллаж байсан туршлагатай хүмүүс орсон байна. Энэ их онцлог нэр дэвшилт болж байна. Энэ нэр дэвшилтийг зөв зохион байгуулсан Гадаад харилцааны сайд, Монгол Улсын Ерөнхийлөгчид бас талархал илэрхийлье.

1 зүйлийг бас тодруулж асууя гэж бодсон юм. Энэ намтар уншиж байхад Даваа гэж хүнээс асууя. Намтрыг нь уншихаар цэргийн хүн ч юм шиг, Ерөнхийлөгчийн зөвлөх байсныг нь харахаар улс төрч ч юм шиг ийм хүн байна. Дээр нь Оросын Холбооны Улсад өмнө нь Элчин сайдаар ажиллаж байсан юм байна. Тэгээд

дуусгаагүй ирсэн юм уу даа. Тэгээд яагаад татагдсан юм. Нэг дэх асуулт. 2019-2021 онд ажиллаж байсан юм байна. Энэ хугацааг харахад бол дуусаагүй юм байна. Яагаад ирсэн юм бэ. Шалтгаан нь юу юм. Одоо тэгээд яагаад явах гэж байгаа юм бэ. Бас зорилго нь юу юм. Энийг өөрөөс нь асууя гэж бодож байна.

Мөнх-Оргил нэр дэвшигчээс энэ Франц улстай хийж байгаа Монгол Улсын тэр Ораногийн ураны хэлэлцээр дээр та ямар шинэ төлөвлөгөөтэй байна. Энэ ажил их чухал боловч гагцхиад, зогсчоод хүлээгдээд байгаа. Энэ ажлын урагшлуулах тал дээр танд ямар саналууд, төлөвлөгөөнүүд байгаа вэ гэдгийг асууя. Ийм асуултууд байна.

Д.Энхтүвшин: Даваа нэр дэвшигч. 6 номерын микрофон.

Д.Даваа: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт цэргийн ч хүн юм шиг, тэгээд дипломат хүн ч юм шиг гээд эхэлж байна. Цэргийн алба, дипломат алба бол хоёулаа төрийн тусгай алба байгаа. Тэгэхээр би төрийн тусгай албанд бол тасралтгүй 40 гаруй жил зүтгэж байна. Цэргийн албаараа Зэвсэгт Хүчний Жанжин штабын дарга хүртлээ албыг хашсан. Ерөнхийлөгчийн зөвлөх гэж яг тэр улс төрийн биш юу талаасаа жил хэртэй ажилласан. Аль ч намын гишүүн биш ийм хүн байгаа.

2019-2021 онд би Оросын Холбооны Улсад Элчин сайдаар ажилласан. Ажиллаж байхдаа бол Монгол Улсын Их Хурал чуулганаараа өгсөн үүрэг даалгавар, Засгийн газар хуралдаанаараа өгсөн үүрэг даалгавар, Аюулгүйн зөвлөл мөн тусгайлан өгсөн үүрэг даалгавруудыг биелүүлэхийн төлөө хийж хичээж ажилласан. Үр дүнд хүрсэн гэж би боддог. Ирээд 2 жилийнхээ ажлын тайланг Батцэцэг сайд тэргүүтэй журмынхаа дагуу яамныхаа удирдлагад тайлангаа тавьсан. Тэр дээр би онц сайн гэсэн дүгнэлт авсан. Тийм учраас би бол ямар нэгэн тийм болж бүтэхгүй, хийж чадаагүйгээсээ болж татагдсан гэж ойлгодоггүй.

Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүх татагдаж ирсний дараагаар бол таныг энэ Газын хоолой Оросын Холбооны Улсаас Хятад руу явах энэ газын хоолойн төсөл маш чухал байна. Энэ төслийг удирдаад, ямар ч байсан гэсэн энэ төлөвлөлтийн хэсгийн юмнуудыг урагшлуулж, амжилттай болгоход хичээнгүйлэн ажиллах ийм үүрэг даалгавар өгсөн. Энэ үүрэг даалгаврыг би өнгөрсөн 3 жил гаруй хугацаанд энэ газын хоолойн төслийн удирдагчаар ажиллаж, өнөөдрийн байдлаар бол төлөвлөлтийн ажил нь дууссан. Энэ хоолой тавигдах үндсэндээ барилгын ажил эхлэх бэлтгэлийг бүрэн хангасан. Энд юу орох вэ гэхээр иж бүрэн зураг төслийн ажлууд дуусаж, Монгол Улсын хуулийн дагуу эксперт хийлгээд батлагдчихсан. Газрын асуудал бол төрийн тусгай хэрэгцээнд авагдсан байгаа.

Д.Энхтүвшин: 3 номер Мөнх-Оргил сайд.

Ц.Мөнх-Оргил: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Монгол Улсаас Франц Улсад суух Элчин сайдаар томилогдоод ажиллавал Монгол Улсын Засгийн газар, Улсын Их Хурлаас өгсөн үүрэг даалгавруудыг нэг бүрчлэн биелүүлэхийн төлөө мэдээж ажиллана. Тэр дундаа Монгол Улсын Засгийн газар, Орано компанийн хооронд байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээг хурдан амилуулах, ажил хэрэг болгох тал дээр Элчин сайд болон Элчин сайдын яамны хамт олноос шалтгаалах бүхнийг хийж ажиллана. Нарийн ширийнийг нь бол би одоохондоо сайн мэдэхгүй байна. Батлагдаад Франц улсаас зөвшөөрөл буюу agree маань ирсний дараа бүх Элчин сайд нар 2 талын харилцааны болон хамтын ажиллагааны нарийн ширийн мэдээлэл рүү орж, мэдээлэл авч, бэлтгэлээ хангадаг. Тэр үед энэ гэрээ

хэлэлцээртэй холбоотой мэдээллийг авч, хаана юу нь явж байгаа юм, хаана юу нь гацаад байгаа, ямар ажил хийх ёстой юм гэдэг тал дээр бол мэдээлэл, баримжаатай болно. Одоогоороо бол надад тийм нарийн мэдээлэл байхгүй байна.

Д.Энхтүвшин: Бум-Очир гишүүн байхгүй байна. Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалтад ороогүй гишүүд байвал санал хураалтад бэлдэж оръё. Ирцэд орчихсон 8 гишүүн байна. Жангабыл гишүүн ирцэд орчихъё. Санал хураалт явуулж эхэлье. Монгол Улсаас гадаад улсад суух зарим Элчин сайд нарыг эгүүлэн татах асуудлаар санал хураалт явуулъя. Энийг нэг дор нь бүгдийг нь явуулна.

1.Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамдинсүрэнгийн Даваасүрэн;

2.Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Мижиддоржийн Цэнгэг;

3.Монгол Улсаас Бүгд Найрамдах Беларусь Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Батсүхийн Баярсайхан;

4.Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Лхагвасүрэнгийн Саяна;

5.Монгол Улсаас Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жигжээгийн Сэрээжав;

6.Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бирваагийн Мандахбилэг;

7.Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Энхтүвшиний Булган;

8.Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Цэрэндоржийн Нарантунгалаг;

9.Монгол Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Баттөмөрийн Энхсүх;

10.Монгол Улсаас Бүгд Найрамдах Казакстан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Доржхүүгийн Баярхүү

11.Монгол Улсаас Бүгд Найрамдах Киргиз Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Содномын Ганхуяг

12.Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Өлзийсайханы Энхтүвшин;

13.Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Сосорбарамын Энхбаяр;

14.Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Гомбосүрэнгийн Мөнхбаяр;

15.Монгол Улсаас Унгар Елсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Сайннямбуугийн Баатаржав;

16.Монгол Улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Уламбаярын Нямхүү;

17.Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Дамдины Гансүх;

18.Монгол Улсаас Арабын Нэгдсэн Эмират Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шижээхүүгийн Одонбаатар;

19.Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Дамбажавын Ганболд;

20.Монгол Улсаас Тайландын Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Амарсанаагийн Төмөр;

21.Бүгд Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жамсрангийн Бямбасүрэн нарыг эгүүлэн татах саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд саналаа өгнө үү. Санал хураалт явуулъя. Санал хураалтад оролцсон гишүүдийн 64,7 буюу 11 гишүүн саналыг дэмжсэн байна. Санал дэмжигдлээ.

Монгол Улсаас гадаад улсад суугаа зарим Элчин сайд нарыг эгүүлэн татах асуудлаарх санал хураалт явуулж дууслаа.

Одоо Монгол Улсын Ерөнхийлөгчөөс зөвшилцөхөөр өргөн мэдүүлсэн Монгол Улсаас гадаад улсад суух зарим Элчин сайд нарыг томилох асуудлаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

1.Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гончигзэвэгийн Тэнгэрийг томилох саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд саналаа өгнө үү. 11 гишүүн дэмжиж, 11 гишүүн дэмжиг дэмжиж 64,7 хувиар санал дэмжигдлээ.

2.Монгол Улсаас Бүгд Найрамдах Австри Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Доржраагийн Мөнхтөрийг томилох саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя гишүүд саналаа өгнө үү. 12 гишүүн дэмжиж, 70,6 хувиар санал дэмжигдлээ.

3.Монгол Улсаас Бүгд Найрамдах Беларусь Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Байгальмааг томилох саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя гишүүд саналаа өгнө үү. 12 гишүүн дэмжиж, 70,6 хувиар санал дэмжигдлээ.

4.Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Авирмэдийн Баттөрийг томилох саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя саналаа өгнө үү. 12 Гишүүн буюу 70,6 хувиар санал дэмжигдлээ.

5.Бүгд Найрамдах Монгол Улсаас Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Ганбаатарын Хуланг томилох саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Саналаа өгнө үү. 12 гишүүн дэмжиж, 70,6 хувиар санал дэмжигдлээ.

6.Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Жагдагийн Оюунбаатарыг томилох саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 12 гишүүн буюу 70,6 хувиар санал дэмжигдлээ.

7.Монгол Улсаас Арабын Бүгд Найрамдах Египет Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Доньжчимбуугийн Бямбадоржийг томилох саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 12 гишүүн буюу 70,6 хувиар санал дэмжигдлээ.

8.Монгол Улсаас Бүгд Найрамдах Итали Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дансрангийн Булганыг томилох саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 12 гишүүн буюу 70,6 хувиар санал дэмжигдлээ.

9.Монгол Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батсүмбэрийн Мөнхжинг томилох саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 12 гишүүн буюу 70,6 хувиар санал дэмжигдлээ.

10.Монгол Улсаас Бүгд Найрамдах Казакстан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гунаажавын Батжаргалыг томилох саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 13 гишүүн буюу 76,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Монгол Улсаас Бүгд Найрамдах Киргиз Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дэмчигийн Тэгшжаргалыг томилох саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 13 гишүүн буюу 76,5 хувиар санал дэмжигдлээ.

12.Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дуламсүрэнгийн Давааг томилох саналыг дэмжье гэсэн Томьёоллоор санал хураалт явуул. Тийм санал хураалт. 13 гишүүн буюу 76,5 хувиар санал дэмжигдлээ.

13.Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Ганболдын Уянгыг томилох саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 13 гишүүн буюу 76,5 хувиар санал дэмжигдлээ.

14.Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Очирын Лхагвасүрэнг томилох саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 13 гишүүн буюу 76,5 хувиар санал дэмжигдлээ.

15.Монгол Улсаас Унгар улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Нямцэрэнгийн Энхтайванг томилох саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 13 гишүүн буюу 76,5 хувиар санал дэмжигдлээ.

16.Монгол Улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэндийн Мөнх-Оргилыг томилох саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 13 гишүүн буюу 76,5%-аар санал дэмжигдлээ.

17.Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батсайханы Болормааг томилох саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт саналыг 13 гишүүн буюу 76,5 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

18.Монгол улсаас Арабын Нэгдсэн Эмират Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Амгалангийн Анандыг томилох саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 13 гишүүн буюу 76,5 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

19.Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лувсанжавын Өлзийтийг томилох саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 13 гишүүн буюу 76,5 хувиар санал дэмжигдлээ.

20.Монгол Улсаас Тайландын Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Вашагийн Оюуг томилох саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 13 гишүүн буюу 76,5%-аар санал дэмжигдлээ.

21.Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Даваахүүгийн Баттөрийг томилох саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 13 гишүүн буюу 76,5 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсаас гадаад улсад суух зарим Элчин сайд нарыг томилох асуудлаар санал хураалт явуулж дууслаа.

Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг зөвшилцсөн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Бум-Очир танилцуулна.

Элчин сайд нарт ажлын амжилт хүсье. Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

11.28 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ